



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 07 өдөр

Дугаар A/146

Булган сум

Г Түүх, соёлын хөдлөх дурсгалт
зүйлийн улсын тооллогын ажлын хэсгийг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2 дахь хэсэг, Соёлын сайдын 2023 оны “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Гишүүд: Н.Мөнхзаяа (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ж.Ганбат (Аймгийн Музейн боловсролын ажилтан)

Э.Халиун (Аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан)

Б.Лхамжав (Аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санч)

Б.Гүррагчаа (Аймгийн Музейн сан хөмрөгч)

Нарийн бичгийн дарга: Т.Бэхтөр (Аймгийн Музейн захирал)

2. Төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Тооллогын ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн болон цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Г.Алдармөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ПУРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010212